



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/89/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>  Сүхбаатар сум  2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
	Утас:7036-3040      Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>
	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 7036-3036      Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a>
	Аудитор: Т.Мөнхзул
	Утас: 7036-2442      Цахим хаяг: <a href="mailto:Munkhzult@audit.gov.com">Munkhzult@audit.gov.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын санал, дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-11
3. Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8. Аудитын гол асуудал	16
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙТИЙН  
НОМЫН САНГИЙН ЗАХИРАЛ  
С. ШИНЭЧИМЭГ ТАНАА

## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № 007-2022/89-НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,513,430.00</b>	<b>8,624,650.00</b>
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>9,513,430.00</b>	<b>8,624,650.00</b>
35400	Хангамжийн материал	9,513,430.00	8,624,650.00
35410	Бичиг хэргийн материал	2,980,320.00	3,128,350.00
35420	Аж ахуйн материал	6,533,110.00	5,496,300.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>226,986,887.00</b>	<b>232,003,326.17</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>226,986,887.00</b>	<b>232,003,326.17</b>
39200	<b>Биет хөрөнгө</b>	<b>217,262,087.00</b>	<b>219,728,436.17</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	136,932,537.85	136,932,537.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	-13,873,236.00	-20,809,854.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6,250,000.05	-7,916,666.73
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	21,672,260.00	22,684,260.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-9,471,274.91	-8,390,193.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,635,660.40	45,635,660.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-35,716,518.64	-30,865,954.88
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,015,563.83	2,015,563.83
39215	Хуримтлагдсан элэгдэл	-953,188.48	-1,101,199.64
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0	0
39217	Ном	67,270,283.00	71,544,283.00
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>9,724,800.00</b>	<b>12,274,890.00</b>
39301	Програм хангамж	2,550,090.00	2,550,090.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,550,090.00	0
39303	Бусад биет бус хөрөнгө	9,724,800.00	9,724,800.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>236,500,317.00</b>	<b>240,627,976.17</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>236,500,317.00</b>	<b>240,627,976.17</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>236,500,317.00</b>	<b>240,627,976.17</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	140,027,818.40	140,027,818.40
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-72,537,002.34</b>	<b>-68,409,343.17</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-68,917,551.45	-72,537,002.34
51220	Тайлант үеийн үр дүн	-3,619,450.89	4,127,659.17
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0	0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	169,009,500.94	169,009,500.94
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>236,500,317.00</b>	<b>240,627,976.17</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>239,123,133.00</b>	<b>251,313,023.84</b>

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,047,550.00</b>	<b>18,059,790.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,047,550.00</b>	<b>18,059,790.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,047,550.00	18,059,790.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>238,075,583.00</b>	<b>233,253,233.84</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>270,000.00</b>	<b>1,624,500.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	1,250,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	270,000.00	374,500.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>237,805,583.00</b>	<b>231,628,733.84</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	237,805,583.00	231,628,733.84
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>242,742,583.89</b>	<b>247,185,364.67</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>242,742,583.89</b>	<b>247,185,364.67</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>242,042,583.89</b>	<b>246,735,364.67</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>174,846,283.00</b>	<b>178,729,630.96</b>
210101	Үндсэн цалин	129,653,403.36	134,528,458.39
210102	Нэмэгдэл	37,908,221.64	36,499,172.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,284,658.00	7,702,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>22,401,500.00</b>	<b>23,013,002.88</b>
210201	Тэтгэврийн даатгал	15,310,100.00	16,076,901.18
210202	Тэтгэмжийн даатгал	1,772,900.00	1,785,435.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,418,000.00	1,428,752.10
210204	Ажилгүйдлийн даатгал	354,800.00	338,274.04
210205	Эрүүл мэндийн даатгал	3,545,700.00	3,383,640.29
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>21,206,390.00</b>	<b>21,353,400.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	724,017.00	817,091.00
210302	Түлш, халаалт	19,753,398.00	19,187,856.00
210303	Цэвэр, бохир ус	728,975.00	1,348,453.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,900,100.00</b>	<b>4,922,780.00</b>
210401	Бичиг хэрэг	1,676,800.00	1,188,530.00
210402	Тээвэр, шатахуун	441,000.00	239,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	622,000.00	674,300.00
210404	Ном, хэвлэл	0	129,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	910,300.00	1,688,115.00
210408	Бараа материал акталсны зардал	0	1,003,535.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>0</b>	<b>150,000.00</b>

**Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0	150,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,800,000.00</b>	<b>1,450,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	250,000.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	1,200,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>0</b>	<b>163,100.00</b>
210702	Дотоод албан томилолт	0	163,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,830,810.00</b>	<b>926,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,376,810.00	651,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	275,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,057,500.89</b>	<b>16,026,950.83</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,057,500.89	16,026,950.83
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>700,000.00</b>	<b>450,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>700,000.00</b>	<b>450,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	450,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-3,619,450.89</b>	<b>4,127,659.17</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-3,619,450.89</b>	<b>4,127,659.17</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	140,027,818.40	169,009,500.94	-68,917,551.45	240,119,767.89
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	140,027,818.40	169,009,500.94	-68,917,551.45	240,119,767.89
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-3,619,450.89	-3,619,450.89
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	140,027,818.40	169,009,500.94	-72,537,002.34	236,500,317.00
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	140,027,818.40	169,009,500.94	-72,537,002.34	236,500,317.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	140,027,818.40	169,009,500.94	-72,537,002.34	236,500,317.00

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

19	Тайлант үеийн үр дүн	0	0	4,127,659.17	4,127,659.17
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	140,027,818.40	169,009,500.94	-68,409,343.17	240,627,976.17

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>238,075,583.00</b>	<b>233,253,233.84</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>238,075,583.00</b>	<b>233,253,233.84</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>270,000.00</b>	<b>1,624,500.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	1,250,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	270,000.00	374,500.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>237,805,583.00</b>	<b>231,628,733.84</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	237,805,583.00	231,628,733.84
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>229,750,883.00</b>	<b>230,269,633.84</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>229,750,883.00</b>	<b>230,269,633.84</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>229,050,883.00</b>	<b>229,819,633.84</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>174,846,283.00</b>	<b>178,729,630.96</b>
210101	Үндсэн цалин	129,653,403.36	136,922,898.05
210102	Нэмэгдэл	37,908,221.64	34,274,880.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,284,658.00	7,531,852.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>22,401,500.00</b>	<b>23,013,002.88</b>
210201	Тэтгэврийн даатгал	15,310,100.00	16,143,549.55
210202	Тэтгэмжийн даатгал	1,772,900.00	1,779,753.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,418,000.00	1,424,142.76
210204	Ажилгүйдлийн даатгал	354,800.00	333,150.70
210205	Эрүүл мэндийн даатгал	3,545,700.00	3,332,406.29
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>21,206,390.00</b>	<b>21,353,400.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	724,017.00	817,091.00
210302	Түлш, халаалт	19,753,398.00	19,187,856.00
210303	Цэвэр, бохир ус	728,975.00	1,348,453.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,968,800.00</b>	<b>4,034,000.00</b>
210401	Бичиг хэрэг	1,830,600.00	1,199,960.00

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	441,000.00	239,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	622,000.00	674,300.00
210404	Ном, хэвлэл	606,000.00	265,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,219,200.00	1,654,840.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>787,100.00</b>	<b>150,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	787,100.00	150,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,010,000.00</b>	<b>1,450,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	210,000.00	0
210602	Тавилга	0	0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	250,000.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	1,200,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>0</b>	<b>163,100.00</b>
210702	Дотоод албан томилолт	0	163,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,830,810.00</b>	<b>926,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,376,810.00	651,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	275,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>700,000.00</b>	<b>450,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>700,000.00</b>	<b>450,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	450,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>8,324,700.00</b>	<b>2,983,600.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>8,324,700.00</b>	<b>2,983,600.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,324,700.00</b>	<b>2,983,600.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>8,324,700.00</b>	<b>2,983,600.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,324,700.00	2,983,600.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-8,324,700.00</b>	<b>-2,983,600.00</b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>238,131,000.00</b>	<b>231,628,733.84</b>	<b>-6,502,266.16</b>	<b>97.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>238,131,000.00</b>	<b>231,628,733.84</b>	<b>-6,502,266.16</b>	<b>97.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>237,931,000.00</b>	<b>231,428,733.84</b>	<b>-6,502,266.16</b>	<b>97.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>183,194,900.00</b>	<b>178,729,630.96</b>	<b>-4,465,269.04</b>	<b>97.00</b>
210101	Үндсэн цалин	138,366,000.00	136,922,898.05	-1,443,101.95	99.00
210102	Нэмэгдэл	36,428,900.00	34,274,880.91	-2,154,019.09	94.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,400,000.00	7,531,852.00	-868,148.00	90.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>24,893,300.00</b>	<b>23,013,002.88</b>	<b>-1,880,297.12</b>	<b>92.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	17,517,500.00	16,143,549.55	-1,373,950.45	92.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,843,900.00	1,779,753.58	-64,146.42	92.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,475,200.00	1,424,142.76	-51,057.24	92.00
210204	Ажилгүйдлийн даатгал	368,800.00	333,150.70	-35,649.30	92.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,687,900.00	3,332,406.29	-355,493.71	92.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>21,353,400.00</b>	<b>21,353,400.00</b>	<b>0.00</b>	
210301	Гэрэл, цахилгаан	1,289,900.00	817,091.00	-472,809.00	63.00
210302	Түлш, халаалт	19,237,000.00	19,187,856.00	-49,144.00	99.00
210303	Цэвэр, бохир ус	826,500.00	1,348,453.00	521,953.00	163.00
210304	Байрны түрээс	0	0	0.00	0.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,643,100.00</b>	<b>5,643,100.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210401	Бичиг хэрэг	624,000.00	961,960.00	337,960.00	154.00
210402	Тээвэр, шатахуун	353,100.00	239,000.00	-114,100.00	68.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	658,800.00	674,300.00	15,500.00	102.00
210404	Ном, хэвлэл	2,617,200.00	2,237,500.00	-379,700.00	85.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	0	-250,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,140,000.00	1,530,340.00	390,340.00	134.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>150,000.00</b>	<b>150,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	150,000.00	150,000.00	0.00	100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,450,000.00</b>	<b>1,450,000.00</b>	<b>0.00</b>	<b>1.00</b>

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	250,000.00	250,000.00	0.00	1.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>163,100.00</b>	<b>163,100.00</b>	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	163,100.00	163,100.00	0.00	100.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,083,200.00</b>	<b>926,500.00</b>	<b>-156,700.00</b>	86.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	651,200.00	651,200.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	275,300.00	-156,700.00	64.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>200,000.00</b>	<b>200,000.00</b>	0.00	100.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>200,000.00</b>	<b>200,000.00</b>	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	200,000.00	0.00	100.00
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>238,131,000.00</b>	<b>231,628,733.84</b>	<b>-6,502,266.16</b>	97.00
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>0</b>	<b>0</b>	0.00	0.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0	0.00	0.00
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>238,131,000.00</b>	<b>231,628,733.84</b>	<b>-6,502,266.16</b>	97.00
320001	Орон нутгийн төсвөөс	238,131,000.00	231,628,733.84	-6,502,266.16	97.00
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>1</b>	
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>18</b>	<b>18</b>	<b>18</b>	
620001	Удирдах ажилтан	1	1	1	
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10	10	
620003	Үйлчлэх ажилтан	7	7	7	
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>18.00</b>	<b>18</b>	<b>18</b>	
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	11.00	11	11	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7	7	

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн */цаашид Нийтийн номын сан гэх/* 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримт болон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, ур чадварын нэмэгдлийг олгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25 -ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Нийтийн номын сангийн эрхэм зорилго нь "Номын сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, номын санг мэдээллийн төв болгон хөгжүүлэх" гэсэн зорилго тавин ажилласан байна.

Нийтийн номын сан нь "Соёлын үнэт зүйл болох ном хэвлэлийн зүйлийг түгээн сурталчлах" гэж үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Нийтийн номын сангийн мөрдөж байгаа аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан "Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөвт байгууллагуудын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус нийтийн номын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны зардлыг бодитоор харуулдаг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 242,742.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,641.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 буюу 2,730.8 мянган төгрөгөөр урьдчилан тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Нийтийн номын сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,127.6 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
A	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	9,513.4	8,624.6	(888.8)
Үндсэн хөрөнгө	226,986.9	232,003.3	5,016.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>236,500.3</b>	<b>240,627.9</b>	<b>4,127.6</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	236,500.3	240,627.9	4,127.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>236,500.3</b>	<b>240,627.9</b>	<b>4,127.6</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 8,624.6 мянган төгрөг болж 888.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 4,956.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 4,841.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, 1,003.6 мянган төгрөгийн материал акталснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 301,087.1 мянган төгрөг болж 5,286.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1,012.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,971.6 мянган төгрөгийн ном худалдан авсан, 1,742.6 мянган төгрөгийн үнэ бүхий 100 ширхэг номыг Сэлэнгэ аймгийн "Ах трейд" ХХК-ын захирал Батдоржоос хандивласан, Үндэсний номын сангаас 559.8 мянган төгрөгийн 46 ширхэг номыг үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 240,627.9 мянган төгрөг болж 4,127.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 12,189.8 мянган төгрөгөөр буюу 5.0 хувиар өссөн нь аймгийн Орон нутгийн Өмчийн газрын зөвшөөрлийн дагуу үндсэн хөрөнгийг дахин үнэлснээс голлон шалтгаалсан байна.

Тайлант оны нийт зардал өмнөх оноос 4,442.8 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна. Энэ нь цалин хөлс болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 4,442.8 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 268,900.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс 30,769.0 мянган төгрөгөөр бууруулж, 238,131.0 мянган төгрөгөөр батлагдсан байна.

Энэ нь цалин, байр ашиглалттай тогтмол зардлыг 18,153.4 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 5,356.9 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 1,300.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хураамж 3,958.7 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 2,000.0 мянган төгрөгөөр тус тус буурч батлагдсантай холбоотой байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 238,131.0 мянган төгрөгийн төсөв баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 231,628.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 231,428.7 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 4,877.6 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130035403 тоот дансанд Соёлын сайдын багцаас 1,250.0 мянган төгрөг, зөөврийн номын сан болон уншигчийн картын орлого 374.5 мянган төгрөг зэрэг нийт 1,624.5 мянган төгрөгийн орлого төвлөрч, 1,012.0 мянган төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авахад, 200.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд, 412.5 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Аудитын явцад онцлох ажил гүйлгээ, асуудал гараагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Нийтийн номын сангийн мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож, 143 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Нийтийн номын сангийн тайлант оны үйл ажиллагаанд 238,131.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 231,428.7 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 2.8 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: *".....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах"* гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 373.0 мянган төгрөгийн албан шаардлага, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 1 зөвлөмж өгснөөс албан шаардлагыг биелүүлж зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	373.0	1	373.0	100
Зөвлөмж	1			-	-
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>373.0</b>	<b>1</b>	<b>373.0</b>	<b>50,0</b>

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 дэх "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 13,221.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1 албан шаардлага / шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлэх / хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 13,221.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

### 4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Зардлын данстай холбоотой асуудал

**1.1 Илрүүлэлт:** Эрхэлж буй ажлыг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр нягтлан бодогч, арга зүйч, номын санч, дежур зэрэг үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг 10-25 хувиар тооцож, нийт 9,406.4 мянган төгрөгийг олгосон байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Дээрх зөрчил нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3 дахь "Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний

албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан **шалгуур үзүүлэлтийн дагуу** албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.” гэсэн заалттай нийцэхгүй ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэн ур чадварын нэмэгдлийг олгож байх.

**Анхан шатны баримттай холбоотой асуудал**

2.1 **Илрүүлэлт:** Тайлант онд 3,814.9 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

2.2 **Өгсөн зөвлөмж:** Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг зөрчсөн тул төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
1	Нийтийн номын сан	3	13,221.3	-	-	-	-	1	-	2	13,221.3